



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 935

Улаанбаатар хот

「Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын」
данс бүртгэлээс тээврийн
хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/165 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 216,547,180.0 /хоёр зуун арван зургаан сая таван зуун дөчин долоон мянга нэг зуун наян/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан 11 тээврийн хэрэгслийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Д.Ядамдорж/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслүүдийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Д.Ядамдорж/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /М.Мандах/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2020 оны 02 дугаар
 сарын 11 өдрийн 013 тоот тушаалын хавсралт



Данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт 576539

/төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Автомашинны марк, улсын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Нийслэлийн Цагдаагийн удирдах газар	Шевролет авео 40-61 УНБ	19,368,000.0	19,368,000.0	0.0
2		Шевролет авео 40-69 УНБ	19,368,000.0	19,368,000.0	0.0
3		Авеко 40-56 УБЗ	20,685,531.0	20,685,531.0	0.0
4		Авеко 40-61 УБЗ	20,685,531.0	20,685,531.0	0.0
5		Авеко 02-93 УБЗ	20,685,531.0	20,685,531.0	0.0
6		Авеко 03-74 УБЗ	20,685,531.0	20,685,531.0	0.0
7		Авеко 40-64 УБЗ	20,685,531.0	20,685,531.0	0.0
8		Авеко 30-01 УНУ	35,433,525.0	35,433,525.0	0.0
9		Уаз-2206 40-31 УБУ	20,600,000.0	20,600,000.0	0.0
10		Уаз-2206 72-76 УБХ	14,000,000.0	14,000,000.0	0.0
11		Уаз-31512 05-34 УБО	4,350,000.0	4,350,000.0	0.0
Дүн			216,547,180.0	216,547,180.0	0.0